



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 81141

Улаанбаатар хот

Ахмад настанд цогц тусламж,  
үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн  
хамтарсан баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.2, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Журам батлах тухай” 2025 оны А/28/27 дугаар тушаалын хавсралтын 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэхэд салбар дундын зохицуулалтыг ханган ажиллах чиг үүрэг бүхий мэргэжлийн хамтарсан багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Гишүүд:

Б.Цогжавхлан

Х.Ганбат

П.Нямжав

Д.Боломж

Нарийн бичиг:

Д.Энхтайван

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Эрүүл мэндийн төвийн дарга

Ахмадын хорооны дарга

2 дугаар хорооны Ахмадын

зөвлөлийн дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний  
хэлтсийн дарга

2. Холбогдох хууль, журам дүрмийн дагуу салбар хоорондын уялдааг хангах ажил арга хэмжээг чанар үр дүнтэй зохион байгуулахыг Ажлын хэсэг (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД